

## ТАНИЛЦУУЛГА

2024 оны 3 дугаар улирлын байдлаар Боловсролын яам болон түүний харьяа байгууллагуудад хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар

2024 оны 10 дугаар сарын 07

Улаанбаатар хот

Иргэдээс төрийн захиргааны төв байгууллага, албан тушаалтанд хандаж ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайланг улирал тутам өссөн дүнгээр гаргаж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлж байна.

Боловсролын яам (цаашид “БЯ” гэх) болон сайдад ажлаа шууд хариуцан тайлагнадаг харьяа байгууллагуудад 2024 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 1879 өргөдөл, гомдол, хүсэлт ирүүлсэн байна.



Иргэдээс Боловсролын яам болон албан тушаалтанд хандан 2024 оны 3 дугаар улиралд нийт 1879 өргөдөл, гомдол ирүүлснээс 28,3% нь цахимаар, 20,1% нь бичгээр, 51,6% нь биечлэн уулзсан байна.

Нийт ирүүлсэн өргөдөл, гомдлыг төрлөөр нь ангилж үзвэл хүсэлт 1545 буюу 82,3%, санал 68 буюу 3,6%, гомдол 266 буюу 14,1% байна.



Хүснэгт. Ирүүлсэн өргөдөл, гомдлын агуулга.

№	Тоо	Хувь	Өргөдөл гомдлын агуулга
1	246	13	Хууль эрх зүй, бодлого, үйл ажиллагааны чиглэлээр
2	660	35.3	Лавлагаа, бүртгэлийн чиглэлээр
3	513	27.3	Оюутны зээл, тусламж, тэтгэлгийн чиглэлээр
4	235	12.5	Төрийн албан хаагчийн ёс зүй, хүний нөөцийн чиглэлээр
5	225	11.9	Санхүүжилт, нийгмийн баталгааны чиглэлээр

### **Шийдвэрлэлт:**

2024 оны 3 дугаар улиралд ирүүлсэн 1879 өргөдөл, санал, хүсэлтийн 1765 буюу 93,9 хувийг шийдвэрлэсэн дүнтэй байна. Шийдвэрлэгдээгүй 113 өргөдөл хугацаандаа судлагдаж байна.

### **Цаашид:**

- Эрхэлсэн асуудлын чиглэлээр боловсруулах хууль тогтоомж, дүрэм, журам болон яамнаас баримтлах бодлого, хэрэгжүүлэх арга хэмжээ, үйл ажиллагаандаа иргэдийн өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд агуулагдсан санал, санаачилгыг тусгахад анхаарна.
- Албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхэд иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэсэн үзүүлэлтийг харгалзан ажиллана.

БОЛОВСРОЛЫН ЯАМ